



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/271

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн үндэстний байгууллагын гамшгийн эрсдэлийг бууруулах газраас Швейцарийн холбооны улсын Женев хотноо 2019 оны 5 дугаар сарын 12-ноос 17-ны өдрүүдэд зохион байгуулах Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн платформ"-д Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга Б.Алтанбадралтыг оролцуулж 6 233 204 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Б.Алтанбадралтын замын болон томилолтын зардалд зарцуулах 6 233 204 төгрөг /зургаан сая хоёр зуун гучин гурван мянга хоёр зуун дөрвөн/-ийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны  
05 дугаар сарын 03-ны өдрийн А/271 дүгээр  
захирамжийн хавсралт

ДЭЛХИЙН ПЛАТФОРМД ОРОЛЦОХОД ШААРДАГДАХ  
ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын төрөл	Хугацаа/хү ний тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Нислэгийн тийз /Улаанбаатар- Москва-Женев- Москва-Улаанбаатар/	2 талдаа /энгийн ангилал/	2.485.100 төгрөг	2.485.100 төгрөг
2	Зочид буудал	5 хоног/1 хүн	200 ам.дол 2639.51=527.902 төгрөг	2.639.510 төгрөг
3	Зам, хоног	7 хоног/1 хүн	60 ам.дол 2639.51=158.370.6 төгрөг	1.108.594 төгрөг
Нийт үнэ				6.233.204 төгрөг

1. Монгол банкны 2019 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хаалтын ханшаар 1 ам.доллар=2.639.51 төгрөг байна.

2. Томилолтын зардлыг "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Сангийн сайдын 2011 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 188 дугаар тушаалын дагуу тооцсон болно.